

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цогт сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/74/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот	2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn Аудитор: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyam1202@gmail.com
--	---------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402 Хөгжил хөрөнгөлөл Жинст баг
Есөнбулаг сум Говь-Алтай аймаг 82099
утас (976) 70 48 34 13
Цахим шуудан govialtai@audit.gov.mn

2025.02.24 № 94

танай _____ -ийн № _____ -т

ЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Д.ЦОГЗОЛМАА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цогт сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, 22 дугаар зүйлийн 22.1, 24 дүгээр зүйлийн 24.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3, 11 дүгээр зүйлийн 11.1, 12 дугаар зүйлийн 12.1, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.2.5 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолтой нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын үнэлгээ хуваарилалт, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

8225920238

- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон баталсан бүтэц орон тооны хязгаарыг зөрчин сумын засаг даргын орлогч 1-ээр ажиллуулан 42,147.0 мянган төгрөгийн цалин олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан,
- Цахим дэлгүүрээс 24,000.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмжийг худалдан аваагүй, худалдан авах ажиллагаа зарлаагүй,
- Зардлын эдийн засгийн ангилал зөрчин 20,000.0 мянган төгрөгийг зарцуулсан,
- Тайлант онд Үйлдвэрчний эвлэлд 4,248.5 мянган төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэлд 19,891.9 мянган төгрөгийг төлөөгүй, өр үүсгэж, төсвийг үр ашиггүй зарцуулсан,
- Засаг даргын нөөц хөрөнгөөс 65,276.0 мянган төгрөгийг мөнгөн аяга, бэлэг дурсгал, дэмжлэг, тусламж, ахмадад нүүрс худалдан авахад зарцуулсан,
- Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчийн зөвшөөрөлгүйгээр иргэнээс 23,000.0 мянган төгрөгийн хандив авч зарцуулсан,
- Аймгийн Засаг даргын Тамгын газраас өр барагдуулах зорилгоор 75,000.0 мянган төгрөгийн олгосон боловч, 24,000.0 мянган төгрөгөөр компьютер худалдан авч, 23,380.0 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан, 7,620.0 мянган төгрөгөөр өр барагдуулсан байна.

Тайлант онд үйлдвэрчний эвлэлд

Тайлант онд 100 жилийн ой тохиож орон нутгийн төсвөөс сумын түүхт 100 жилийн ойн арга хэмжээнд 100,000.0 мянган төгрөгийг хүлээн авснаас 50,000.0 мянган төгрөгийг ойн нээлт, хаалтын үйл ажиллагааг зохион байгуулах, урлаг уран сайхны бүх үйл ажиллагааг зохион байгуулсан. 50,000.0 мянган төгрөгийг баяр наадмын талбайн хиймэл зүлэг худалдан авахад тус тус зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн бусадтай туслахыг дэмжсэн байна. Бидний авч үзсэн Засаг даргын нөөц хөрөнгөөс Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Аймгийн Засаг даргын орлогч 1-ээр илүү ажиллуулан 24,794.5 мянган төгрөгийн цалин олгосон, Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын 100 жилийн ойд 105,189.0 мянган төгрөгийг давхардуулан зарцуулж, 65,276.0 мянган төгрөгийг мөнгөн аяга, бэлэг дурсгал, дэмжлэг, тусламж, ахмадад нүүрс худалдан авахад зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 8 зорилт 93 арга хэмжээний хэрэгжилт 94.5 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Гүнжидмаа
ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	356,250,226.0	430,129,476.0
33	АВЛАГА	53,000,000.0	23,000,000.0
33500	Бусад авлага	53,000,000.0	23,000,000.0
33510	Байгууллагаас авах авлага	53,000,000.0	23,000,000.0
35	БАРАА МАТЕРИАЛ	303,250,226.0	397,129,476.0
35100	Түүхий эд материал	-	53,000,000.0
35110	Тусгай зориулалттай материал	-	53,000,000.0
35400	Хангамжийн материал	76,385,225.0	117,264,475.0
35410	Бичиг хэргийн материал	1,347,350.0	835,800.0
35420	Аж ахуйн материал	39,965,100.0	64,269,600.0
35430	Сэлбэг хэрэгсэл	15,199,500.0	12,679,500.0
35450	Барилгын засварын материал	13,565,942.0	17,560,942.0
35470	Бусад хангамжийн материал	6,307,333.0	21,918,633.0
35600	Мал амьтад	226,865,001.0	226,865,001.0
36	НӨӨЦИЙН БАРАА	-	10,000,000.0
36300	Тэжээлийн нөөц	-	10,000,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,928,121,047.4	1,809,958,106.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,928,121,047.4	1,809,958,106.8
39200	Биет хөрөнгө	1,687,747,047.4	1,569,584,106.8
39201	Барилга, байгууламж, орон сууц	890,112,888.9	989,112,888.9
39202	Хуримтлагдсан элэгдэл	(509,566,534.2)	(557,660,124.8)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	284,666,709.0	264,676,709.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(164,640,216.4)	(164,965,534.7)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	83,253,353.8	91,593,353.8
39206	Хуримтлагдсан элэгдэл	(44,680,511.6)	(56,195,773.2)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,861,420.0	41,350,820.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,347,420.0)	(26,772,830.2)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	80,000,000.0	80,000,000.0
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,309,075,542.0	1,309,075,542.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	(243,988,184.1)	(400,630,944.0)
39300	Биет бус хөрөнгө	240,374,000.0	240,374,000.0
39303	Бусад биет бус хөрөнгө	240,374,000.0	240,374,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,284,371,273.4	2,240,087,582.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	37,210,608.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	37,210,608.8
41300	Өглөг	-	37,210,608.8
41360	Бусад өглөг	-	37,210,608.8
41361	Байгууллагад төлөх өглөг	-	37,210,608.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,284,371,273.4	2,202,876,974.0
51	Засгийн газрын хувь оролцоо	2,284,371,273.4	2,202,876,974.0
51100	Засгийн газрын оруулсан капитал	327,928,674.8	327,928,674.8
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	327,928,674.8	327,928,674.8
51200	Хуримтлагдсан үр дүн	1,876,250,334.5	1,794,756,035.2
51210	Өмнөх үеийн үр дүн	867,513,910.0	1,876,250,334.5

Цогт сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

51220	Тайлант үеийн үр дүн	1,008,736,424.6	(81,494,299.4)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	80,192,264.0	80,192,264.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,284,371,273.4	2,240,087,582.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,009,975,860.0	1,590,683,623.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,202,686,295.0	119,671,300.0
120	Нийтлэг татварын бус орлого	1,202,686,295.0	119,671,300.0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,183,186,295.0	104,000,000.0
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	19,500,000.0	15,671,300.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	807,289,565.0	1,471,012,323.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,041,265.0	284,003,323.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	24,500,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	94,561,830.0	258,908,323.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,479,435.0	595,000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	704,248,300.0	1,187,009,000.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	704,248,300.0	1,187,009,000.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,001,239,435.4	1,672,177,922.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,001,239,435.4	1,672,177,922.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	979,781,513.8	1,630,096,480.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	398,589,673.8	660,992,509.0
210101	Үндсэн цалин	277,979,756.7	433,466,683.0
210102	Нэмэгдэл	73,242,022.0	195,661,216.0
210104	Урамшуулал	30,240,086.0	10,483,452.0
210105	Гэрээт ажлын хөлс	17,127,809.2	21,381,158.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,742,179.0	102,401,999.8
210201	Тэтгэврийн даатгал	34,289,990.0	78,001,999.8

Цогт сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	3,868,631.0	6,100,000.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,086,106.0	3,050,000.0
210204	Ажилгүйдлийн даатгал	766,556.0	3,050,000.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,730,896.0	12,200,000.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,928,688.6	61,455,608.8
210301	Гэрэл, цахилгаан	7,324,248.6	8,986,108.8
210302	Түлш, халаалт	44,604,440.0	52,469,500.0
2104	Хангамж, бараа материалын зардал	40,223,245.0	25,563,413.0
210401	Бичиг хэрэг	3,670,550.0	8,930,450.0
210402	Тээвэр, шатахуун	32,825,670.0	11,579,463.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,966,470.0	3,146,500.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,748,055.0	1,907,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,082,720.0	16,379,700.0
210604	Урсгал засвар	15,082,720.0	16,379,700.0
2107	Томилолт, зочны зардал	15,458,000.0	17,970,000.0
210702	Дотоод албан томилолт	15,458,000.0	17,970,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,415,292.0	3,512,079.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	246,292.0	498,525.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,000.0	410,792.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	330,000.0	253,000.0
210807	Газрын төлбөр	1,500,000.0	2,349,762.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	391,341,715.4	741,821,170.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	149,905,850.0	500,079,630.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.0	1,749,200.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	239,435,865.4	239,992,340.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,457,921.6	42,081,442.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	38,461,935.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	30,147,935.0

Цогт сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	7,500,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	814,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	21,457,921.6	3,619,507.2
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,365,036.6	2,986,277.2
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	92,885.0	633,230.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,008,736,424.6	(81,494,299.4)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,008,736,424.6	(81,494,299.4)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	807,289,565.0	1,524,012,323.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	807,289,565.0	1,524,012,323.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,041,265.0	337,003,323.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	24,500,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	94,561,830.0	311,908,323.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,479,435.0	595,000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	704,248,300.0	1,187,009,000.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	704,248,300.0	1,187,009,000.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	807,289,565.0	1,506,182,923.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	807,289,565.0	1,506,182,923.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	732,831,643.4	1,441,101,480.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	398,589,673.8	656,744,000.0
210101	Үндсэн цалин	277,979,756.7	429,218,174.0
210102	Нэмэгдэл	73,242,022.0	195,661,216.0
210104	Урамшуулал	30,240,086.0	10,483,452.0
210105	Гэрээт ажлын хөлс	17,127,809.2	21,381,158.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,742,179.0	82,510,000.0
210201	Тэтгэврийн даатгал	34,289,990.0	58,110,000.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,868,631.0	6,100,000.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,086,106.0	3,050,000.0
210204	Ажилгүйдлийн даатгал	766,556.0	3,050,000.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,730,896.0	12,200,000.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,258,688.6	48,385,508.8
210301	Гэрэл, цахилгаан	7,324,248.6	8,986,108.8

Цогт сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

210302	Түлш, халаалт	40,934,440.0	39,399,400.0
2104	Хангамж, бараа материалын зардал	41,182,460.0	39,781,363.0
210401	Бичиг хэрэг	3,905,500.0	8,418,900.0
210402	Тээвэр, шатахуун	32,704,390.0	26,579,463.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,106,470.0	3,146,500.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,466,100.0	1,636,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,969,500.0	17,854,700.0
210604	Урсгал засвар	9,969,500.0	17,854,700.0
2107	Томилолт, зочны зардал	15,458,000.0	17,970,000.0
210702	Дотоод албан томилолт	15,458,000.0	17,970,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,725,292.0	3,662,079.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	246,292.0	498,525.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,000.0	410,792.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	330,000.0	403,000.0
210807	Газрын төлбөр	1,500,000.0	2,349,762.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	166,905,850.0	574,193,830.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	164,905,850.0	572,444,630.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.0	1,749,200.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,457,921.6	65,081,442.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	38,461,935.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	30,147,935.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	7,500,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	814,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	74,457,921.6	26,619,507.2
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,365,036.6	2,986,277.2
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	53,092,885.0	23,633,230.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	17,829,400.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	17,829,400.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	17,829,400.0
2200	Дотоод эх үүсвэрээр	-	17,829,400.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	17,829,400.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(17,829,400.0)

Цогт сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,928,674.8	80,192,263.9	867,513,909.9	1,275,634,848.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	327,928,674.8	80,192,263.9	867,513,909.9	1,275,634,848.7
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	1,008,736,424.5	1,008,736,424.5
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,928,674.8	80,192,263.9	1,876,250,334.5	2,284,371,273.3
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	327,928,674.8	80,192,263.9	1,876,250,334.5	2,284,371,273.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	327,928,674.8	80,192,263.9	1,876,250,334.5	2,284,371,273.3
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-81,494,299.3	-81,494,299.3
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	327,928,674.8	80,192,263.9	1,794,756,035.1	2,202,876,973.9

Цогт сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,240,284,600.0	1,184,022,722.8	56,261,877.2	95.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,240,284,600.0	1,184,022,722.8	56,261,877.2	95.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,191,062,600.0	1,145,560,787.8	45,501,812.2	96.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	660,000,000.0	656,744,000.0	3,256,000.0	99.5
210101	Үндсэн цалин	218,000,000.0	429,218,174.0	(211,218,174.0)	196.9
210102	Нэмэгдэл	442,000,000.0	195,661,216.0	246,338,784.0	44.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,510,000.0	82,510,000.0	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	58,110,000.0	58,110,000.0	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,100,000.0	6,100,000.0	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,050,000.0	3,050,000.0	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,050,000.0	3,050,000.0	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	12,200,000.0	12,200,000.0	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,399,400.0	48,385,508.8	13,891.2	100.0
210301	Гэрэл, цахилгаан	9,000,000.0	8,986,108.8	13,891.2	99.8
210302	Түлш, халаалт	39,399,400.0	39,399,400.0	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	34,714,000.0	33,001,900.0	1,712,100.0	95.1
210401	Бичиг хэрэг	9,920,000.0	8,418,900.0	1,501,100.0	84.9
210402	Тээвэр, шатахуун	19,800,000.0	19,800,000.0	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.0	3,146,500.0	(146,500.0)	104.9
210404	Ном, хэвлэл	500,000.0	-	500,000.0	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.0	-	100,000.0	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,394,000.0	1,636,500.0	(242,500.0)	117.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,500,000.0	32,344,100.0	155,900.0	99.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,500,000.0	13,489,400.0	10,600.0	99.9
210604	Урсгал засвар	19,000,000.0	18,854,700.0	145,300.0	99.2
2107	Томилолт, зочны зардал	19,399,200.0	17,970,000.0	1,429,200.0	92.6
210702	Дотоод албан томилолт	19,399,200.0	17,970,000.0	1,429,200.0	92.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,340,000.0	3,662,079.0	677,921.0	84.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	500,000.0	498,525.0	1,475.0	99.7
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	450,000.0	410,792.0	39,208.0	91.3

Цогт сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.0	403,000.0	47,000.0	89.6
210807	Газрын төлбөр	2,940,000.0	2,349,762.0	590,238.0	79.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	309,200,000.0	270,943,200.0	38,256,800.0	87.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	307,200,000.0	269,194,000.0	38,006,000.0	87.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.0	1,749,200.0	250,800.0	87.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,222,000.0	38,461,935.0	10,760,065.0	78.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,222,000.0	38,461,935.0	10,760,065.0	78.1
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	39,222,000.0	30,147,935.0	9,074,065.0	76.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,500,000.0	7,500,000.0	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.0	814,000.0	1,686,000.0	32.6
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,240,284,600.0	1,184,022,722.8	56,261,877.2	95.5
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,240,284,600.0	1,184,022,722.8	56,261,877.2	95.5
320001	Орон нутгийн төсвөөс	1,240,284,600.0	1,184,022,722.8	56,261,877.2	95.5

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	337,003,323.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	337,003,323.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	313,370,093.0
2104	Хангамж, бараа материалын зардал	6,779,463.0
210402	Тээвэр, шатахуун	6,779,463.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	306,590,630.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	306,590,630.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,633,230.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,633,230.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,633,230.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	337,003,323.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	337,003,323.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,953,500.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	294,454,823.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,595,000.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 11,001.8 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- Төсвийн гүйцэтгэлээр зардал, төсвийн хэлбэлзлээс 1,001.8 мянган төгрөгөөр зөрүүтэй
- Тайлант онд өвс худалдан авахаар 10,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч, орлого аваагүй шууд зардалд бичсэн.

Залруулагдаагүй нийт 369,994.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 369,994.0 мянган төгрөгийн 13 зөрчил² илэрч, 24,794.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 270,199.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар 8 албан шаардлага, 75,000.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль болон баталсан бүтэц орон тооны хязгаарыг зөрчин сумын Засаг даргын орлогч 1-ээр ажиллуулан 24,794.5 мянган төгрөгийн цалин олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т "Нийслэлийн Засаг дарга хоёр, аймаг, дүүрэг, сумын Засаг дарга нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглоно", 5.3-т "Засгийн газрын агентлагийн дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд ажиллуулахыг хориглоно", Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоол "Аймгийн засаг даргын Тамгын газрын бүтэц орон тооны хязгаарыг тогтоох тухай" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2 Албан шаардлага

1. Сумын Засаг даргын Тамгын газар баталсан орон тооны хязгаараас Засаг даргын орлогч 1-ээр илүү ажиллуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т "Нийслэлийн Засаг дарга хоёр, аймаг, дүүрэг, сумын Засаг дарга нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглоно", Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоол "Аймгийн засаг даргын тамгын газрын бүтэц орон тооны хязгаарыг тогтоох тухай" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү ажиллаж байгаа Засаг даргын орлогчийг чөлөөлж, зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Цахим дэлгүүрээс 24,000.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмжийг худалдан аваагүй, худалдан авах ажиллагаа зарлаагүй нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цахим дэлгүүрээс худалдан авч зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Зардлын эдийн засгийн ангилал зөрчин 28,594.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зардлын эдийн засгийн ангилал зөрчин гүйлгээ хийдэг зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

4. Тайлант онд Үйлдвэрчний эвлэлд 4,248.5 мянган төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэлд 19,891.9 мянган төгрөгийг төлөөгүй, өр үүсгэж, төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" , 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Цогт сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

5. Засаг даргын нөөц хөрөнгөөс 65,276.0 мянган төгрөгийг мөнгөн аяга, бэлэг дурсгал, дэмжлэг, тусламж, ахмадад нүүрс худалдан авахад зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"; Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байх зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

6. Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын 100 жилийн ойд 105,189.0 мянган төгрөгийг давхардуулан зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.1-т "Нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна", 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байх зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

7. Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчийн зөвшөөрөлгүйгээр иргэнээс 23,000,0 мянган төгрөгийн хандив авч зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-д "Төсвийн байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан дараах тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийн хэлбэрээр тусламж, хандив авч болно", 25.5-д "Дараах тохиолдлыг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэн төсвийн байгууллага хандив, тусламж авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хандив авдаг зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

8. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж Засаг даргын нөөц хөрөнгөөс 65,276.0 мянган төгрөгийг бэлэг дурсгал, дэмжлэг, тусламж, ахмадад нүүрс өгөхөд зарцуулсан, Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын 100 жилийн ойд 105,189.0 мянган төгрөгийг давхардуулан зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"; 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг

Цогт сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

дурсгалын зүйл худалдан авах;" гэж заасантай нийцэхгүй нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийг үр ашигтай зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Нэмэлт санхүүжилттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Аймгийн Засаг даргын Тамгын газраас өр барагдуулах зорилгоор 75,000.0 мянган төгрөгийн олгосон боловч, 24,000.0 мянган төгрөгөөр компьютер худалдан авч, 23,380.0 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан, 7,620.0 мянган төгрөгөөр өр дарсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Цогт сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Цогт сумын Засаг даргын Тамгын газар	Төсвийн гүйцэтгэлээр зардал, төсвийн хэлбэлзлээс 1,001.8 мянган төгрөгөөр зөрүүтэй	1	1,001.8		-	1	1,001.8	1	1,001.8	-	-	-	-
	Тайлант онд өвс худалдан авахаар 10,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч, орлого аваагүй шууд зардалд бичсэн.	1	10,000.0			1	10,000.0	1	10,000.0				
дүн		2	11,001.8	-	-	2	11,001.8	2	11,001.8	-	-	-	-

Цогт сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Цогт сумын Засаг даргын Тамгын газар	Төрийн хэмнэлтийн тухай хууль болон баталсан бүтэц орон тооны хязгаарыг зөрчин сумын Засаг даргын орлогч 1-ээр ажиллуулан 24,794.5 мянган төгрөгийн цалин олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	24,794.5	1	24,794.5							
	Сумын Засаг даргын Тамгын газар баталсан орон тооны хязгаараас Засаг даргын орлогч 1-ээр илүү ажиллуулж байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-
	Цахим дэлгүүрээс 24,000.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмжийг худалдан аваагүй, худалдан авах ажиллагаа зарлаагүй	1	24,000.0				1	24,000.0				
	Зардлын эдийн засгийн ангилал зөрчин 28,594.0 мянган төгрөгийг зарцуулсан. /хавсралтаар/	1	28,594.0				1	28,594.0				
	Тайлант онд Үйлдвэрчний эвлэлд 4,248.5 мянган төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэлд 19,891.9 мянган төгрөгийг төлөөгүй, өр үүсгэж, төсвийг үр ашиггүй зарцуулсан.	1	24,140.5				1	24,140.5				

Цогт сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	Засаг даргын нөөц хөрөнгөөс 65,276.0 мянган төгрөгийг мөнгөн аяга, бэлэг дурсгал, дэмжлэг, тусламж,ахмадад нүүрс худалдан авахад зарцуулсан байна.	1	65,276.0			1	65,276.0			
	Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын 100 жилийн ойд 105,189.0 мянган төгрөгийг давхардуулан зориулалт бусаар зарцуулсан.	1	105,189.0	1	24,794.5	1	105,189.0			
	Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчийн зөвшөөрөлгүйгээр иргэнээс 23,000,0 мянган төгрөгийн хандив авч зарцуулсан.	1	23,000.0			1	23,000.0	-	-	
	Аймгийн Засаг даргын Тамгын газраас өр барагдуулах зорилгоор 75,000.0 мянган төгрөгийн олгосон боловч, 24,000.0 мянган төгрөгөөр компьютер худалдан авч, 23,380.0 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан, 7,620.0 мянган төгрөгөөр өр даржээ.	1	75,000.0					1	75,000.0	
	Дүн	9	369,994.0	1	24,794.5	7	270,199.5	1	75,000.0	-

Цогт сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1				1		
	НИЙТ		1				1		